

## ≡ ≡ УЙЛ ЯВДАЛ ≡ ≡

“МОНГОЛ ХЭЛ ШИНЖЛЭЛ”  
сэдэвт магистрант, докторантын эрдэм шинжилгээний хурал болов

Монгол Улсын Их Сургуулийн ууган тэнхимиийн нэг Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимиийн 75 жилийн ой эндээс өдөр тохиож байна. Тус ойт тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхим байгуулагдсаны 75 жилийн ой, Академич Ш.Лувсанванданы мэндэлсний 110 жилийн ойт зориулсан “Хэл шинжлэл” хөтөлбөрийн магистрант, докторантуудын эрдэм шинжилгээний хурлыг 2020 оны 12-р сарын 4-ний өдөр цахим хэлбэрээр зохион байгууллаа.

Хуралд тус тэнхимиийн докторант Ё.Мөнхбат “Монголын нууц товчоон” дахь ‘qarmaldusu’ хэмээх угийн утгыг нягтлах нь (манж-тунгус хэлний баримтаар),

докторант Чой Юун Со “Орчин цагийн монгол хэлний хэв нь дагавар уу, нөхцөл үү?”, докторант Н.Оюундарь “Өгүүлбэрзүйн задлуур программд зориулан монгол хэлний өгүүлбэрийн бүтцийг тэмдэглэх нь”, докторант М.Билгүүнчимэг “Жангарын туулийн хэлэнд холбогдох судалгааны тойм”, докторант Х.Бямбажав “Галдан бошогт хааны тамганы бичээсийг дахин унишиж тодруулах нь”, магистрант Б.Бадамханд “Монгол хэлний зүйл хуваасан толь бичгийн бүтцийн тухай” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлснээс докторант Ё.Мөнхбат тэргүүн байр, Х.Бямбажав дэд байр эзэлж дурсгалын зүйлээр шагнуулав.

\* \* \*

“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ 780 ЖИЛ” болон  
“МОНГОЛ БИЧГИЙН СУРАХ БИЧИГ” үзэсгэлэн гарав

Монгол Улсын Их Сургуулийн Номын сангийн “Ховор ном, монгол бичгийн уншлагын танхим”-ын нээлтийн үеэр Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимээс Монголын Нууц Товчооны 780 жилийн ойт зориулсан бүтээлүүд болон Монгол бичгийн сурах бичгүүдийг дэлгэн үзүүлэв.


Монголын Нууц Товчооны 780 жилийн ойн үзэсгэлэнд Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхимиийн эрдэмтэн Ц.Дамдинсүрэнгийн 1947 онд хэвлүүлсэн бүтээлээс эхлээд эрдэмтэн Т.Дашцэдэн (1985) эрдэмтэн Ш.Чоймаа (2006, 2011) нарын бүтээл, мөн дэлхийн монгол судлаачдын бүтээлийн дээжээс 50 гаруйг сонирхуулсан байна.

Монгол бичгийн сурах бичгийн бүтээлийн үзэсгэлэнд тус тэнхимиийн ахмад эрдэмтэн Б.Ринчен, Д.Чойжилсүрэн, Х.Далхжав, Чой.Лувсанжав, Ц.Шархүү, Т.Дашцэдэн, Ш.Чоймаа, Ц.Шагдарсүрэн, Г.Гантолгох нарын бүтээлээс гадна тэнхимдээ одоо ажиллаж буй багш М.Баярсайхан, Ч.Баттулга, Б.Баяртуул, Б.Даваасүрэн, О.Дэмчигмаа, Т.Отгонтуул, Э.Мөнх-Учрал, Б.Энхсувд нарын монгол бичгээ шимтэн суралцагч наарт зориулсан ном, сурах бичиг, дүрмийн лавлах, толь бичгүүдийг дэлгэн харуулснаараа онцлог байв.

\* \* \*

“МОНГОЛ-СОЛОНГОСЫН ДИПЛОМАТ ХАРИЛЦААНЫ 30 ЖИЛ:  
ХЭЛ, СОЁЛЫН ХАРИЛЦАА” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал болов

МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургуулийн Хүмүүнлэгийн ухааны салбарын Монгол хэл, хэлшинжлэлийн тэнхим болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Солонгос Судлалын Академитай хамтран зохион байгуулсан “Монгол-Солонгосын дипломат харилцааны 30 жил: Хэл, соёлын харилцаа” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд Монгол, БНСУ, ОХУ, БНХАУ, Герман, Унгар, АНУ зэрэг орны эрдэмтэн судлаачид, ахисан түвшний суралцагчид 2020 оны 11 дүгээр сарын 27-ний өдөр хоёр орны хэл, соёлд холбогдох долоон салбар хуралдаанд цахимаар оролцлоо. Тус хуралд



Солонгос, монгол судлалын сэдвүүд: Хятад сурвалж дээр тулгуурлах нь  
Бүтэц хэлшинжлэл: Авиазүй ба бүтээврийн судалгаа  
Хэлний сэтгэцийн судалгаа: Солонгос-монгол хэлний харьцуулал  
Боловсрол болон соёлын асуудлууд  
Уламжлалт соёлын судалгаа  
Утга зохиол судлал  
Сурвалж судлал  
гэсэн сэдвийн хүрээнд 17 илтгэл хэлэлцүүлж, илтгэл тус бүрд холбогдох асуудлаар асуулт хариулт, санал шүүмж бүхий хэлэлцүүлэг өрнөлөө. Хурлын дараагаар илтгэлүүдийг эмхэтгэн Language and cultural exchange цувралын эхний дугаарт хэвлэн нийтлэв.